



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/05

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

“Цагдаагийн албаны тухай Монгол улсын хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.5, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 351 дүгээр тушаалаар баталсан “Аюулгүй байдлыг хангах журам” /код 113/-ын 113.3.4, 2015 оны Б/99 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам” /код 136/-ын 136.4.2-ын “а”, “д” дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах, орон тооны бус ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар шинэчилэн байгуулж, хариуцах ажлын чиглэлийг хоёрдугаар хавсралтаар батлан ажиллуулсугай.


2. Тус газрын дотоод аюулгүй байдлыг хангах журмыг үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж, хийж гүйцэтгэсэн ажлын төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /цагдаагийн дэд хурандаа О.Батбаатар/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалыг гарсантай холбогдуулан Цагдаагийн газрын даргын 2015 оны А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Анхбаатар/-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



А.БАТБАЯР

Tushaal

45000026

Цагдаагийн газрын даргын 2016 оны  
02 дугаар сарын 20-ны өдрийн А/05  
тоот тушаалын хавсралт

**ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ОРОН ТООНЫ  
БУС АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

-О.Батбаатар-Дэд бөгөөд Эрүүгийн  
цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд  
хурандаа

Нарийн бичгийн дарга:

-Г.Ганзориг-Эрүүгийн ахлах төлөөлөгч,  
цагдаагийн хошууч,

Гишүүдэд:

-Ю.Чулуунбаатар-Хэрэг бүртгэх, мөрдөн  
байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч,

-Т.Лхагвасүрэн-Нийтийн хэв журам хамгаалах  
тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа,

-Б.Батбаяр-Замын цагдаагийн тасгийн дарга,  
цагдаагийн дэд хурандаа,

-Б.Анхбаатар-Төлөвлөлт, зохион  
байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн  
хошууч,

-Н.Дашдаваа-Ахлах нхягтлан бодогч,  
цагдаагийн ахмад,

-Д.Эрдэнэцэцэг-Хүний нөөцийн мэргэжилтэн,  
цагдаагийн дэслэгч,

-Н.Гүррагчаа-Холбоо, мэдээллийн инженер,  
цагдаагийн ахлах дэслэгч.

**ЦАГДААГИЙН ГАЗАР**